

V.ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

32.Эдийн засгийн аюулгвй байдал гэж дотоод нооц бололцоогоо ашиглан нохон вйлдвэрлэл явуулах, ард тvmнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжvвлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нохцолд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бvтэц бvрдсэн байдлыг хэлнэ.

Эдийн засгийн аюулгвй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бvрэн эрхт байдлын тулгуур vндэс мон.

33.Эдийн засгийн аюулгвй байдлыг хангахад сорог нолоолж болох гадаад хvчин зvйлvвд:

1/ гадаад худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хогжvвлэх боломж хязгаарлагдах буюу хаагдах;

2/ бусад улс орны тvvхий эдийн хавсарга болох;

3/ стратегийн ач холбогдол бvхий экспортын барааны vнэ унах, зах зээл vгвй болох;

4/ эдийн засгийн стратегийн ач холобгдол бvхий салбарт нэг улсаас шууд хараат болох.

34.Эдийн засгийн аюулгвй байдалд сорог нолоо vзvвлж болох дотоод хvчин зvйлvвд:

1/ экологийн бодлого алдагдаж, ус, ой, мод, ходоо аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ багасах;

2/ бvс нутгийн хогжлийн ялгаа гvнзгийрэх, эдийн засгийн тэнцвэр алдагдах;

3/ монгол малын удмын сан, vр тарианы нутагшмал сорт хомсдох;

4/ гаалийн бодлого алдагдаж, Монгол Улс, ард тvмний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгvй эд зvйлс орж ирэх, тосвийн орлогын эх vвсвэр багасах, vндэсний вйлдвэрлэлд соргоор ноолоох;

5/ улсын урсгал тосвийн алдагдал осох, Монгол Улсын монгон тэмдэгт-тогрогийг хамгаалах торийн бодлого алдагдах;

6/ инфляци vсрэнгvй нэмэгдэн тогрогийн ханш унаж, амьжиргааны доод тvвшингээс доогуур орлоготой айл орхийн тоо олшрох;

7/ бусад улс буюу уолон улсын байгууллагад ортэй болж дарамт шахалт, хараат байдалд орох;

8/ гадаадын иргэд, харьяалалгvй хvмvвс Монголд олноороо суурьших, vндэсний мэргэжилтэй боловсон хvчин, ажиллах хvчин олноороо гадаадад цагаачлах;

9/ ажилгvйчvвд, тvвний дотор ходолморийн насны ходолморлох чадваргvй хvн амын тоо хэт ихсэх.

35.Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам:

Нэг.Дараах чиглэлээр торийн нэгдсэн бодлоготой байх:

- эдийн засгийн бvтцийн оорчлолт;
- эдийн засгийн гадаад харилцаа;
- ор толборийн асуудал;
- тосвийн бодлого;
- монгоний бодлого;
- шинжлэх ухаан-технологийн бодлого;
- эдийн засгийн тайлан, бvртгэл, мэдээлэл.

Хоёр. 1 /эдийн засгийн аюулгвй байдлыг хангахад гvйцэтгэх vвргийг нь харгалзан дараах салбаруудыг стратегийн ач холбогдолтой гэж vзэх:

а/vйлдвэрлэлийн салбарт:

- хvнс, ходоо аж ахуй;
- уул уурхайн аж вйлдвэр;
- хонгон аж вйлдвэр;
- химийн аж вйлдвэр.

б/дэд бvтцийн салбарт:

- эрчим хvч;
- тvлш;
- холбоо, мэдээлэлжvвлэлт;
- зам тээвэр.

2/ дараах чиглэлээр гадаадын хоронго оруулалтыг хохvвлэн дэмжих:

- стратгийн ач холбогдолтой салбаруудыг хогжvвлэх;
- экспортын болон хvнсний нооцийг нэмэгдvвлэх вйлдвэрлэлийг хогжvвлэх;
- импортыг орлуулж болох зарим тvвхий эд, техникийн эд анги, сэлбэг хэрэгсэл зэргийг дотооддоо вйлдвэрлэх.

Гурав.Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах торийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд дараахь чиглэл баримтлах:

1/ эдийн засаг, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх;

2/ орон нутаг харьцангуй биеэ даан хөгжих нохцолыг бүрдүүлж чадахуйц эдийн засгийн мужлал тогтоон цогцолбороор хөгжүүлэх;

3/ экологийн цэвэр бүтээгдэхвэл үйлдвэрлэх, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэл хөгжүүлэх чиг баримтлах;

4/ хүн амыг хүнс, оргон хэрэглээний бараагаар хангах ноогийг жил бүр тогтоон бүрдүүлж, сэлбэн шинэтгэж байх, стратегийн ач холбогдолтой зарим барааг дотооддоо үйлдвэрлэх;

5/ Монгол Улсын валютын гадаад ноогийг 2-оос доошгүй сарын нийт импорттой тэнцэх хэмжээнд байлгах;

6/ монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаалах;

7/ дэлхийн улс орнуудтай худалдаа-эдийн засгийн харилцаа хөгжүүлэхдээ эдийн засагт, нэн ялангуяа стратегийн ач холбогдолтой салбарт нэг буюу хэсэг орны ноёрхол тогтох хараат байдалд орох, түүхий эдийн хавсарга болохоос сэргийлэх. Манай Улстай чөлөөтэй харилцах сонирхлыг ондор хөгжилтэй, нолоо бүхий улс орнуудад буй болгох;

8/ Монгол Улсын далайд гарах эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулах;

9/ эдийн засгийн аюулгүй байдлаа хангах үүднээс хорш орнууд, орно, дорнын ондор хөгжилтэй орнуудтай хоёр болон оон талын худалдаа-эдийн засгийн эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг оргожүүлэх, бүс нутгийн худалдаа-эдийн засгийн сүлжээнд оорийн байр суурьтай болох;

10/ нэг орноос авах стратегийн ач холбогдолтой тvvхий эд, тоног тохооромж, мэргэжилтэн, ажилчдын тоо хэмжээг vндэсний аюулгвй байдалд нолоолохооргвй байх хэмжээнд байлгах;

11/ гадаад орны хоронго оруулагчдад vзvvлэх аливаа хонгололт, тэдний эдийн засгийн сонирхлыг хамгаалах арга хэмжээг монголын vндэсний вйлдвэрлэгчид, хоронго оруулагчдад vзvvлдэг хонгололт, эдийн засгийн нохцолоос давуутай болохоос сэргийлж, хяналт тавих;

12/ гадаадад улс, олон улсын байгуулагаас авах зээлийн хэмжээг тvvнийг толох хугацааны толборийн боломжоос хэтрvvлэхгвй байлгах;

13/ 1990 оноос омо авсан зээл, зээлийн хvvгийн толборийг оорийн болон зээлдvvлэгч орны ашиг сонирхол, ор анх буй болсон шалтгааныг харгалзан олон улсын жишгийн дагуу шийдвэрлэх;

14/ гадаад худалдаанд экспортыг нэмэгдvvлэх бодлого явуулахдаа боловсруулалт буюу эцсийн боловсруулалт хийсэн бvтээгдэхvvн гаргах.